



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 09 сарын 26 өдөр

Дугаар А/681

Булган сум

“Булган ус” ХХК-тай нэмэлт гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.4, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.4, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хуралдааны 2023 оны 08 дугаар сарын 04-ний өдрийн XVII хуралдааны 5 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хүн ам, бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх зориулалтаар Хишиг-Өндөр суманд шинээр худаг гаргах ажлыг 27,000,000 (хорин долоон сая) төгрөгөөр “Булган ус” ХХК-тай нэмэлт гэрээ байгуулах эрхийг Хүнс, хөдөө аж ахуйн газар (Ч.Амгалан)-т олгосугай.

2. Ажил гүйцэтгэгчтэй холбогдох хууль, журмын дагуу гэрээ байгуулж, гүйцэтгэлд нь хяналт тавьж, хүлээн авах ажлыг зохион байгуулахыг Хүнс, хөдөө аж ахуйн газар (Ч.Амгалан)-т даалгасугай.

3. Ажлыг холбогдох хууль, журам, гэрээнд заасан техникийн үзүүлэлтийн дагуу гүйцэтгэж, хүлээлгэн өгөхийг “Булган Ус” ХХК (Д.Нямболд)-д үүрэг болгосугай.

4. Тус ажлыг хууль, журам, гэрээний дагуу 2023 оны Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний сангаас санхүүжүүлэхийг нягтлан бодогч (Б.Бумцэнд)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ